

МОНГОЛЫН ЗАЛУУЧУУДЫН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, ҮЙЛ БАЙДАЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ

С.МӨНХБАТ

МУИС. Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч,
доктор, профессор

Б.БАТ-ЭРДЭНЭ

Улс төрийн судлалын тэнхимийн докторант

Түүхүүр үг: ардчилал, үнэт зүйл, эрх чөлөө, ухамсар, нийгмийн идэвх, шинэчлэл, идэвх, санаачлага

Товч утга: Монгол Улс ардчиллын зарчим, үнэт зүйлсийг өөрийн орны хөрсөнд нутагшуулан багагүй хугацаа өнгөрч, чамлахааргүй амжилт олжээ. Энэ хугацаанд хүний эрх, эрх чөлөөний тухай үзэл баримтлалд тулгуурласан ардчилсан Үндсэн хуультай болж, эрх зүйт төр, иргэний нийгмийг бэхжүүлэх үйл хэрэгт шийдвэртэй алхмуудыг хийсний үр дүнд Монголчуудын хувьд ардчиллын үзэл санаа өдөр тутмын амьдралын бодит үйл хэрэг болжээ. Хүний эрх, эрх чөлөөний тулгуур зарчмуудыг эрх зүйн хувьд баталгаажуулж, олон намын тогтолцоог бүрдүүлж, чөлөөт сонгууль явуулж, улс төрийн соёлд өөрчлөлт орж, улмаар улс орныхоо ардчилсан үйл явцын материаллаг болон оюун санааны суурь нөхцөлийг бүрдүүлж чадсан зэрэг бидний олсон ололт амжилт багагүй гэдгийг харуулж байна.

Гэвч ардчиллыг өөрийн хөрсөнд баттай суулгаж, төлөвшүүлэхийн тулд анхаарах шаардлагатай зүйлс байна. “Ардчиллын хүрсэн төвшин, оншлог, шинж, тулгарч буй асуудал, цаашдын төлөв байдлын талаар онолын зөв бодитой төсөөллийг нийгэмд бий болгох хэрэгтэй”¹ гэдгийг цаг үе харуулж байна. Тийм учраас ардчиллын төлөвшилтэд суурь нөлөө үзүүлэгч хүчин зүйлсийн судалгааг нарийвчлан хийх зайлшгүй шаардлага тулгарч байна. Энд анхаарах ёстой нэг зүйл бол Монголын залуучуудын улс төрийн оролцоо, үйл байдал, түүнд гарч буй өөрчлөлтийн асуудал мөн.

* * *

1990 оноос өмнөх нийгмийн тогтолцоонд залуучуудын улс төрийн оролцоо, нийгмийн идэвх санаачилга ихэнхдээ өөрсдийн хүсэл зоригийн хэрэг биш төрөөс, намаас зааварлан сурталдах хэлбэрээр явагдаж байсныг бид мэднэ. Харин эдүгээ залуучуудын нийгэм, улс төрийн оролцоо түүний идэвхжилтийг улс төрийн системийн шинж байдал, ардчиллын хэм хэмжээтэй шууд холбон үзэх шаардлага зүй ёсоор урган гарч байгаа билээ.

Монголын ард иргэдийн сэтгэл зүйд ардчиллыг хөгжүүлэх хүсэл эрмэлзлэл баттай бий болсныг манай судалгааны байгууллагуудын хийсэн судалгааны дүнгээс харж болно. Ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжиж цаашид энэ замаар замнах нь зайлшгүй гэдэг дээр манай иргэдийн дийлэнх нь (85%)² санал нэгтэй байгаа дүн гарчээ. Мөн гадаадын судлаачид ч өөр өөрсдийн үнэлэлт дүгнэлтээ өгсөөр байна. Тухайлбал Азийн барометр судалгааны эмхэтгэлд “Монгол нь Зүүн Европоос гадна коммунизмаас чөлөөт өрсөлдөөнт олон намын систем бүхий капиталист ардчилалд амжилттай шилжсэн цорын ганц орон гэдгийг тэмдэглэх хэрэгтэй”³ гэсэн байна.

Ардчиллын хөгжилд тохиолдож буй зарим хүндрэл, бэрхшээл нь манай иргэдийн ардчиллыг ойлгох хэт ерөнхий хийсвэр ойлголт, төсөөлөл, улс төрийн ухамсар, соёлын доогуур түвшинтэй холбоотой бөгөөд үүнийг ч зарим судалгааны дүнгээс харж болно. Тухайлбал, Нийгмийн Ардчиллын хүрээлэн, Максима, Сант марал, Социологийн боловсрол төв болон ШУА-ийн ФСЭХ зэрэг байгууллагаас хийсэн давтамжит судалгааны дүнгээр манай иргэд сонгогчид ардчиллыг эрх чөлөө, чөлөөт байдал, ил тод шударга зарчим, хувийн өмч зэрэг ардчиллыг үнэлэх ерөнхий ойлголт талаас нь үнэлж, иргэдийн оролцоо, ард түмний засаглал, чөлөөт сонгууль, тайлагнах, хариуцлага хүлээх зарчим зэрэг ардчиллыг үнэлдэг чанарын талын асуудлуудыг орхигдуулах, мэдэхгүй байх зэрэг түгээмэл дутагдууд байсаар байна. Тухайлбал, Сант Марал судалгааны байгууллагаас хийсэн судалгаагаар⁴ “Монголын ардчилал таны сэтгэлд хэр нийцдэг вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогсодын 24.3% нь нийцдэг, 41.3% нь бага зэрэг нийцдэг, 18.1% нь бараг

¹ Бод-Эрдэнэ Б. Монгол дахь ардчилсан өөрчлөлтийн онолын зарим асуудал. 127 дахь тал. Философи эрх зүйн судал. ХХII боть

² Хүмүүс: улс төр-нийгмийн амьдрал сэдэвт суурь судалгаа. Нийгмийн Ардчиллын хүрээлэн. 2012 оны IX сар.

³ До Чүл Шин. Зүүн Ази дахь гуравдугаар давалгаа: Харьцуулсан ба динамик төлөв. Азийн барометр. УБ., 2008. 14 дахь тал.

⁴ Улс төрийн барометр. Сант Марал судалгааны төвийн судалгаа. УБ., 2009 оны 4-р сар

нийшдэггүй, 9.3% нь нийшдэггүй, 7% нь мэдэхгүй гэж хариулсанаас үзвэл, ардчилал Монголын хөрсонд бодит агуулгаараа, тохирсон хэв загвараараа буух шаардлагтайг харуулж байгаа болно.

Ардчиллын хөгжил төлөвшилд хүн амын томоохон хэсэг болох залуучуудын идэвх оролцоо чухал үүрэг гүйцэтгэнэ. Иймээс Монголын залуучуудын улс төрийн оролцоо, үйл байдлын өөрчлөлт, цаашдын чиг хандлагыг улс төр, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлсийн нөлоөллөөр судалж тодруулах нь нэн тэргүүний алхам мөн хэмээн үзэж байна.

Өнөөдөр манай залуучуудын улс төрийн оролцоо, үйл байдал улс төр, нийгмийн олон хүчин зүйлсээс хамааран тогтворт бус динамик шинж давамгайлсан төлөв байдалд байна. Бид Монголын залуучуудын улс төрийн оролцоо, үйл байдлын шинж, цаашдын чиг хандлагыг тодруулан гаргахын тулд энэ талаар хийгдсэн эрдэмтэн судлаачдын судалгаа, сонгогчдын дунд хийсэн тоон болон чанарын судалгаанууд дээр үндэслэн анализ хийхийг оролдов.

Монголын залуучуудын улс төрийн оролцоо, үйл байдал нь *сонгуулийн бус үед болон сонгуулийн кампанийн үед төлөв байдлын хувьд нэлээдгүй ялгаатай болдог*. Сонгуулийн кампанийн үеэр залуучуудын улс төрийг оролцоо тэдгээрийн үйл байдлын өөрчлөлт, хувирал нь “их хөөсрөлт”-тэй байдаг бол сонгуулийн бус үед энэ хөөсрөлт буурч улс төрд хандах энгийн горимд шилжиж байдаг.

Өнөөдрийг хүртэлх хугацаанд Монголын залуучуудын улс төрийн оролцоо, үйл байдал нь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, улс төрийн үзэгдэл, үйл явцыг даган хувьсан өөрчлөгдөж ирсэн бөгөөд энэхүү чиг хандлагыг тодорхойлохын тулд цаг хугацааны хувьд сонгуулийн мөчлөгтэй нь уялдуулан авч үзэх нь арга зүйн хувьд оновчтой байдаг. Түүнчлэн залуучуудын улс төрийн оролцооны цаашдын чиг хандлага түүнд гарч буй өөрчлөлт, шилжилтийг нийгэм, эдийн засаг, оюун санаа, социаль хүрээнд өрнөж буй өөрчлөлтэй уялдуулан авч үзэх нь ч мөн ач холбогдолтой. Учир нь залуучуудын улс төрийн оролцоо, үйл байдалд шууд нөлөө үзүүлэгч суурь хүчин зүйлс бол нийгэм, ахуйн (эдийн засгийн) өөрчлөлтүүд байдаг.

2012 онд ШУА-ийн ФСЭХ-ээс хийсэн давтамжит судалгаагаар залуучуудын нийгэм, улс төрийн амьдралыг сонирхох байдал, оролцоонд томоохон өөрчлөлт гарч эхэлжээ.

Хүснэгт I.

Залуучуудын улс төрийн оролцоо, нийгмийн амьдралыг сонирхдог байдал⁵

Д/д	Хариулт	1988	2003	2010	2013	2016
1	Үргэлж анхааран сонирхож байдаг	23%	31.6%	27.6%	55.5%	56.1%
2	Өөр холбоотой асуудлаар хааяа сонирхдог	37%	55.2%	59.5%	32.8%	35.9%
3	Огт сонирхдоггүй	40%	11.5%	12.9%	10.5%	8.0%
	Бүгд			100%	100%	100%

Эндээс харахад залуучуудын улс төрийн оролцоо, нийгмийн идэвх жилээс жилд нэмэгдэж буй дүр зураг харагдаж байна. Хамгийн сүүлийн судалгаагаар 2 залуу хүн тутмын нэг нь улс төрийн оролцоо өндөр, идэвхтэй, харин 2 хүн тутмын нэг нь дунд зэргийн сонирхогч, 10 хүн тутмын нэг нь идэвхгүй гэсэн үнэлгээг хийж болохоор байна. 1988 онтой харьцуулахад залуучуудын улс төрийн оролцоо 33%-иар өсч, улс төр, нийгмийн амьдралд идэвхгүй хандагч залуучуудын жин 30%-иар буурсан байна.

Өнөөдөр Монголчуудын амьдралын хэв маяг материаллаг талаасаа их өөрчлөгдөж байна. Сүүлийн жилүүдэд нэн ялангуяа байгалийн баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулж эхэлснээр нийгэмд баян хоосны ялгаа улам нэмэгдэж энэ нь нийгмийн гишүүдийн сэтгэл зүй, тэдний улс төрийн үйл байдалд чухал нөлөө үзүүлж эхэллээ. Зах зээл хөгжих тусам эдийн засгийн мэдлэг, мэргэшил, удирдлага, санхүү менежментийн арга барил өөрчлөгдөн хэн овсгоотой, хөрөнгө мөнгөтэй нь, хэн мэдлэг боловсролтой нь цаашид хол явахыг энэ үед залуучууд хүчтэй мэдэрч эхэлж байна.

Өмчийн харилцаан дээр суурилсан либераль ардчиллын үнэт зүйлс хүчтэй нэвтэрч байгаатай холбогдон Монголчуудын хамтак, нийтэч зан үйлийн уламжлал алдагдаж түүний оронд амиа хичээх, хувна бодох үзэл, сэтгэлгээ манай иргэдэд (ялангуяа залуучуудад) төлөвшиж байна. Сэтгэлгээний энэхүү төлөвшил залуучуудын улс төрийн оролцоо, үйл байдалд нөлөөлж болно. Энэ тухай академич Г.Чулуунбаатар “Эх орон, ард түмэн, нийгмийн дэвшлийн эрх ашгийг илүү дээдлэх нийгэм, хүмүүнлэгийн итгэл үнэмшилээс хувийн эрх чөлөө, хангалийн төлөө хүсэл эрмэлзлэл шилжиж байна”⁶ гэж дүгнэсэн нь

⁵ Монголын залуучуудын нийгмийн дүр төрх. (ХХ-ХХI зууны зааг үе) судалгааны эмхэтгэл. ШУА.ФСЭХ. УБ., 2012 болон Залуучуудын талаар баримтлах төрийн бодлого сэдэвт суурь судалгааны дүн. НАМЗХ, Социологийн боловсрол төв. УБ., 2013 он, Ардчилсан дэвшлийн хүрээлэн. Хүмүүс: аж амьдрал, нийгэм-улс төрийн оролцоо” сэдэвт судалгаа. УБ., 2016

⁶ Г.Чулуунбаатар. Олон нийтийн санаа болол дахь сэтгэл зүйн зорчлүүд. ХХ, ХХI зууны зааг үеийн Монголын нийгэм, иргэншийн өөрчлөлт УБ., 2008. 14 дэх

манай улсын хувьд залуучуудын итгэл үнэмшил, оюун санааны хөгжил толовшилд бодитой дүгнэлт хийж, төрийн тодорхой бодлого авч хэрэгжүүлийг цаг үеийн хэрэгцээ шаардлага болжээ.

Монгол Улс хүний хөгжлийн үзүүлэлтээр 186 орноос 108, амьдралын чанарын үзүүлэлтээр 192 орноос 107, эдийн засгийн орсөлдох чадвараар 144 орноос 93-т тус тус жагсаж байна. Энэ бол тийм ч таатай үзүүлэлтүүд биш бөгөөд бид Африкийн хөгжил буурай орнуудын түвшинд л байна гэсэн үг. Нийгмийн Ардчиллын Хүрээлэнгийн хийсэн цуврал судалгаануудаар⁷ хүн амын дунд хамгийн тулгамдаж буй асуудлуудад дараах асуудлууд орсон байна. Үүнд,

- | | |
|-----------------------------------|---------|
| - Ажилгүйдэл, ядуурал | - 20.5% |
| - Архидалт, архичид | - 20.3% |
| - Авиалга, хээл хахууль | - 18.5% |
| - Орлогын хомдол | - 15.1% |
| - Улс төрийн хариуцлагагүй байдал | - 10.2% |
| - Байгаль орчны бохирдол | - 9.2% |

Судалгааны дүнгээс харахад иргэдийн ахуй амьдрал сайнгүй байгаа бөгөөд ядуурлын түвшин 36%, баян хоосны ялгааг хэмждэг жиний кофициент 0.36% байгаа нь өндөр үзүүлэлт юм. Энэ процент 0.40%-иас дээш гарвал тухайн улсад нийгмийн бүлгүүдийн хоород мөргөлдөөн тэмцэл бий болох хөрс суурь бүрддэг гэж үздэг. Нийгэм- эдийн засгийн энэ сүл дорий байдал нь манай залуучуудын улс төрийн оролцоо, үйл байдлын тогтворт шинжид нөлөөлж байна. Судалгаагаар ажилгүйчүүд, ядуучууд, орлогын хомдолтой нийгмийн бүлэг, тэр дундаа залуучуудын улс төрийн идэвх оролцоо эрс сүл байгаа бөгөөд тэдний улс төрийн үйл байдалд гадны хүчин зүйлийн нөлөө их (70-80%) байгаа нь тогтоогдсон байна.

Монголчуудын улс төрийн оролцоонд нөлөөлөгч социаль өөрчлөлтийн хүрээнд гарч буй өөр нэг томоохон үзэгдэл бол сонгогчдын насын бүтцэд гарч буй өөрчлөлт юм. Өнөөдөр сонгуулийн насанда хүрсэн нийт 1 сая 863 мянган сонгогчийн 60% буюу 1 сая 100 мянган сонгогч нь 18-35 хүртэлх насын залуучууд байна. 1990 онд төрсөн хүүхэд өнөөдөр 24 настай бөгөөд тэд ардчилсан нийгмийн тогтолцоонд хүмүүжин төлөвшсөн иргэд. Тиймээс тэдэнд өмнөх нийгмийн талаар ойлголт, төсөөлөл хомс зөвхөн ардчиллын тухай, ардчилсан нийгмийн тухай л ойлголт төсөөлөл тэдний улс төрийн үйл байдлын үндсэн шинжийг нь бүрдүүлж байна. Энэ нь тэдний хувьд ардчиллыг дэмжих үндсэн үйл байдал болж түүнийгээ улс төрийн оролцоо, дэмжлэгээр хангана гэсэн бодол санаа түгээмэл байна. Үүнийг доорх хүснэгтээс харна уу?

Хүснэгт 2.

Та аль намын нэр дэвшигчийг дэмжих вэ? Насны бүлгээр⁸

		МАН	АН	МАХН
Насны бүлгээр	18-35	34.4%	50.0%	15.6%
	35-45	33.9%	41.0%	16.3%
	46-60	40.1%	38.0%	17.6%
	61-ээс дээш	45.7%	35.5%	16.7%

Дээрх хүснэгтээс харахад сонгогчдын насын бүтцэд гарч буй өөрчлөлт залуучуудын улс төрийн оролцоо, байр суурийг нийт сонгогчдын дунд хүчтэй нөлөөлөгч болгон хувиргахад хүргэж байна.

Харин залуучуудын оршин суугаа газар, хүйсийн байдал, боловсролын түвшин зэргээс шалтгаалан тэдний улс төрийн оролцоо харилцан адилгүй байгаа нь зарим байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох байдлаас харагдаж байна. Үүнийг судалгааны дүнд тулгуурлан харуулья.

Хүснэгт 3.

Нийгэм, улс төрийн оролцооны байдал, байршил, хүйс боловсролоор⁹

	Улс төрийн намын үйл ажиллагаанд	Олон нийтийн байгууллагад	Залуучуудын байгууллагад	Шашны байгууллагад
Хүйс				
Эрэгтэй	47.2%	55.0%	44.4%	16.7%

⁷ Нийгмийн Ардчиллын Хүрээлэнгээс 2011, 2012, 2013 онуудад хийсэн Хүмүүс: Улс төр-нийгмийн амьдрал сэдэвт суурь судалгаануудын дүн мэдээ.

⁸ Нийгэм, улс төрийн цаг үеийн судалгаа. Нийгмийн Ардчиллын Хүрээлэн. УБ., 2013 оны 5-р сар

⁹ Монголын залуучуудын нийгмийн дүр төрх. (ХХ-XXI зууны зааг үе) судалгааны эмхэтгэл. ШУА ФСЭХ. УБ., 2012. 80 дахь тал

Эмэгтэй	52.8%	45.0%	55.3%	83.3%
Боловсрол				
Дээд	52.0%	52.6%	70.4%	16.7%
Тусгай дунд	8.4%	10.5%	3.7%	16.1%
Бүрэн дунд	27.9%	21.1%	11.1%	50.0%
Бүрэн бус дунд	9.1%	18.2%	11.7%	16.7%
Бага, боловсролгүй	2.6%	0	3.7%	0
Амьдрал буй газар				
Хот	57.3%	63.9%	40.7%	33.4%
Хөдөө	42.7%	63.2%	59.3%	66.7%

Ийнхүү дээрх хүснэгтээс харахад залуучуудын улс төрийн оролцоонд эмэгтэйчүүд, дээд боловсролтой, хотын залуус илүү оролцож байгаа бол олон нийтийн байгууллагын үйл ажиллагаанд оролцогчид мөн дээд боловсролтой, эрэгтэйчүүд, хөдөөгийн залуусын оролцоо өндөр байна. Харин олон нийтийн байгууллагуудын үйл ажиллагаа болон улс төрийн намын үйл ажиллагаанд оролцох залуусын оролцооны байдлыг 2003 он болон 2012 оноор харьцуулан харвал 2003 онд улс төрийн намын үйл ажиллагаанд оролцогч залуусын жин 30.8%-тай байсан бол 2012 онд 18.6%-тай болж даруй 12.2%-иар, олон нийтийн байгууллагын үйл ажиллагаанд оролцогч залуусын жин 2003 онд 34.0%-тай байсан бол 2012 онд 25.9%-тай болж даруй 8.1%-иар тус тус буурсан үзүүлэлт гарсан байна.

Дүгнэлт

1990 оноос хойш нийгмийн бүх хүрээг хамарсан өөрчлөлтийн үйл явц, тэр дундаа ардчиллын хөгжлийг судлахдаа хэт ерөнхийлсөн байдлаар хандаж ирснээс үүдээд түүнд эерэг болон сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлүүдийн талаар нарийвчлан задлан шинжилсэн судалгаа орхигдож ирсэн. Үүний нэг нь залуучуудын талаарх төрийн зөв бодлого юм.

Монголын залуучуудын улс төрийн оролцоо, нийгмийн идэвхийн цаашдын чиг хандлагыг бүрэн дүүрэн тодорхойлохын тулд нэгдүгээрт, Монгол Улсын замнаж буй ардчилал, зах зээлийн эдийн засгийн үзэл баримтлалуудад ямар байр сууринаас хандаж байгаагаар тодруулах нь чухал ач холбогдолтой.

Хүснэгт 4.

Улс төр, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагатай санал нийлж буй эсэх¹⁰

Хариултын сонголт	Санал бүрэн нийлж байна	Зарим талаараа	Санал огт нийлэхгүй	Үнэлгээний үзүүлэлт	Дундаж үнэлгээ
Ардчилал бол Монголын ирээдүй мөн	34.9%	50.4%	6.1%	91.2%	2.3%
Зах зээлийн эдийн засаг Монголын ирээдүй мөн	27.0%	60.7%	5.3%	90.1%	2.2%
Сонгуулийн үр дүнд миний санал нөлөөлөхгүй	22.7%	29.7%	36.8%	18.9%	1.8%
Олон намын системийг хүлээн зөвшөөрөх байдал	24.1%	44.0%	15.4%	68.0%	2.1%

Судалгааны дүнгээс харахад эхний хоёр үзүүлэлтийн хувьд үнэлгээ харьцангуй өндөр буюу хүлээн зөвшөөрөх хандлага эерэг тал руугаа хэлбийлттэй байгаа нь үнэлгээний үзүүлэлт болон дундаж үнэлгээгээр нотлогдож байна. Үнэлгээний шалгуур үзүүлэлт (0-100) 67.0% байна. Энэ нь дээрх дөрвөн хандлагад нийтдээ ийм үнэлгээ өгч байна гэсэн үг ба өөрөөр хэлбэл, улс төр, нийгэм, эдийн засгийн дээрх үзэл баримтлалуудыг хүлээн зөвшөөрөх байдал дундажаас дээгүүр байна гэж ойлгож болохоор байна. Цаашид ч залуучуудыг өдөр тутмын амьдрал, нийгэм улс төрийн оролцооноос шууд хамааралтай байна гэдгийг улам бүр ухааруулж, тэдний өөрсдийн үүрэг оролцоог өндөрөөр үнэлэх байдлыг улам бүр онцлох шаардлагатай юм.

¹⁰ Монголын залуучуудын нийгмийн дүр төрх. (ХХ-XXI зууны зааг үе) судалгааны эмхэтгэл. ШУА.ФСЭХ. УБ., 2012. 83 дахь тал

НОМ ЗҮЙ:

1. Б.Болд-Эрдэнэ. Монгол дахь ардчилсан өөрчлөлтийн онолын зарим асуудал. Философи эрх зүйн судалал. XXII боть
2. Dalton, R. Citizen politics: Public opinion and political parties in advanced industrial democracies. Washington. 2008
3. До Чүл Шин. Зүүн Ази дахь гуравдугаар давалгаа: Харьцуулсан ба динамик төлөв. Азийн барометр. УБ., 2008
4. Залуучуудын талаар баримтлах төрийн бодлого сэдэвт суурь судалгааны дүн. НАМЗХ, Социологийн боловсрол төв. УБ., 2013
5. Монголын залуучуудын нийгмийн дүр төрх. (XX-XXI зууны зааг үе) судалгааны эмхэтгэл. ШУА.ФСЭХ. УБ., 2012
6. Нийгмийн Ардчиллын Хүрээлэнгээс 2011, 2012, 2013 онуудад хийсэн Хүмүүс: Улс төр-нийгмийн амьдрал сэдэвт суурь судалгаануудын дүн мэдээ
7. Г.Чулуунбаатар. Олон нийтийн санаа бодол дахь сэтгэл зүйн зөрчлүүд. XX, XXI зууны зааг үеийн Монголын нийгэм, иргэншлийн өөрчлөлт. УБ., 2008
8. Улс төрийн барометр. Сант Марал судалгааны төвийн судалгаа. УБ., 2009